



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/496

Ховд

Дэд ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 35 дугаар зүйлийн 35.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Нийгмийн даатгалын тухай хуулийн 33 дугаар зүйл, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны “Хяналт шалгалтын аян зохион байгуулах тухай” А/120 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Даатгуулагч /иргэн/-д хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоосон байдалд хяналт шалгалт хийх аян”-ыг аймгийн хэмжээнд 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 05-ны өдрийн хооронд зохион байгуулах “Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн”-ийг нэгдүгээр хавсралтаар, “Дэд ажлын хэсгийн ажлын төлөвлөгөө”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. “Даатгуулагч /иргэн/-д хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоосон байдалд хийх хяналт шалгалтыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх ажлын хэсгийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан, цаашид авах арга хэмжээний саналыг танилцуулж ажиллахыг дэд ажлын хэсгийн ахлагч /Т.Дэлгэрсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
09 дүгээр сарын 20-ны өдрийн
А/496 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дэд ажлын хэсгийн ахлагч:	Т.Дэлгэрсайхан	- Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Д.Нямгарав	- Мэргэжлийн хяналтын газрын Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч
Гишүүд:	П.Эрдэнэчулуун	- Мэргэжлийн хяналтын газрын дарга
	Н.Батчулуун	- Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
	Л.Билэгдэмбэрэл	- Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга
	Ц.Мягмарсүрэн	- Эрүүл мэндийн газрын дарга
	П.Гэрэлсүрэн	- Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирал
	С.Дорж	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн бодлого хариуцсан мэргэжилтэн
	Р.Жамила	- Мэргэжлийн хяналтын газрын Эмчилгээ чанарын хяналтын улсын байцаагч
	Б.Цагаанбилэг	- Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний байгууллагын төлөөлөл

-оОо-


 Аймгийн Засаг даргын 2021 оны
 09 дүгээр сарын 20-ны өдрийн
 а/496 дугаар захирамжийн
 2 дугаар хавсралт

ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хийх ажлын чиглэл	Хугацаа	Хариуцах байгууллага
1	Аймгийн Засаг даргын захирамжаар хяналт шалгалт хийх дэд ажлын хэсгийг байгуулж, комиссд хийгдэх ажлыг танилцуулах хурал зохион байгуулах	2021.09.15-17	ЗДТГазар
2	Бүх сум, өрхийн эмч нарт иргэдийн амбулаторийн картыг цуглуулан албажуулж, ирүүлэх албан тоотыг боловсруулан хүргүүлэх	2021.09.16-09.20 -ны хооронд	Эрүүл мэндийн газар
3	Бүх сумын Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн байцаагч, мэргэжилтнүүдэд хамтран ажиллах албан тоотыг хүргүүлэх	2021.09.15-09.16 -ны хооронд	НДХэлтэс ХХҮГазар
4	Аймгийн ТВ болон радио, цахим хаягаар зарыг тараах	2021.09.16	ЗДТГазар НДХэлтэс МХГазар
5	Дахин магадлалд хамрагдах иргэдийн нэрсийн жагсаалтыг гаргаж сум өрхийн эмч, нийгмийн даатгалын байцаагч, нийгмийн халамжийн мэргэжилтнүүдэд хүргүүлэх	2021.09.15-09.16 -ны хооронд	НДХэлтэс ХХҮГазар
6	Дахин магадлал хийх ажлын байрыг бэлдэж, иргэдийн амбулаторийн картыг хүлээн авч шалгуулаад буцааж хүргүүлэх ажлын хэсгийг томилох	2021.09.15	ЗДТГазар МХГазар ЭМГазар
7	Эмнэлгийн хувийн хэрэг, нийгмийн даатгалын хувийн хэрэг, нийгмийн халамжийн хувийн хэргийг массивтайгаа тулган шалгах	Аяны хугацаанд	МХГазар НДХэлтэс ЭХМК-ын нарийн бичгийн дарга
8	Хяналт шалгалтад хамрагдах иргэдийн эмнэлгийн анхан шатны баримт бичигт тулгуурлан хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэсэн үндэслэлд цахим хэлбэрээр хяналт, шалгалт хийх	Аяны хугацаанд	ЭМГ, БОЭТ
9	Дахин магадлалын үед шаардлагатай тохиолдолд төрөлжсөн мэргэжлийн эмчийн хамт иргэнийг биеэр дуудан хамтарсан үзлэг, шинжилгээг хийх	Аяны хугацаанд	НЭ-ийн амбулаторын нарийн төрөлжсөн мэргэжлийн эмч, комиссын гишүүд МХГазрын Эмчилгээ чанарын хяналтын улсын байцаагч

10	Хяналт шалгалтын явцын тайланг 7 хоног бүрийн пүрэв гаригт холбогдох газарт ажлын хэсгийн ахлагчаар хянуулан баталгаажуулж, ажлын хэсгийн нарийн бичгийн даргад хүргүүлэх	Аяны хугацаанд	Дэд ажлын хэсгийн нарийн бичгийн дарга
11	Комиссын хурал бүрийн тэмдэглэлийг хөтлөж явах, хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллах	Аяны хугацаанд	Дэд ажлын хэсэг
12	Ажлын хэсгийн гишүүн тус бүрийн хийж гүйцэтгэсэн ажлын тайланг гаргаж нэгтгэх	2021.10.03	Нарийн бичгийн дарга
13	Аяны тайланг "Тайлан хүлээн авах маягт"-ын дагуу 2021 оны 10 сарын 05-ны дотор ажлын хэсгийн нарийн бичгийн даргад явуулах	2021.10.05	Дэд ажлын хэсэг
14	Ажлын тайлан, мэдээ, хурлын тэмдэглэл холбогдох баримт бичгийг зохих журмын дагуу архивлах	2021.10.05	Дэд ажлын хэсэг

-oOo-